

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2021 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ
ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН ХОРООНЫ 6 ДУГААР САРЫН 22-НЫ ӨДӨР
/МЯГМАР ГАРАГ/-ИЙН ХУРАЛДААНЫ ТОВЬЁГ**

№	Баримтын агуулга	Хуудас
1.	Хуралдааны товч тэмдэглэл:	1-8
2.	Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл	9-70
	1.Нийтийн мэдээллийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд <i>/Засгийн газар 2021.05.19-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/</i>	10-29
	2.Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд <i>/Засгийн газар 2021.05.19-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/</i>	29-47
	3.Цахим гарын үсгийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд <i>/Засгийн газар 2021.05.19-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/</i>	47-57
	4.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл <i>/Улсын Их Хурлын гишүүн С.Чинзориг нарын 4 гишүүн 2021.05.14-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/</i>	57-64
	5.“Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний комиссын гишүүнд нэр дэвшигчийн хүсэлтийг хүлээн авах товыг сунгах тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл	64
	6.“Томилгооны сонсголын тов тогтоох тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл	64-68
	7.Ажлын хэсэг байгуулах тухай Байнгын хорооны тогтоолын төсөл <i>/Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг Байнгын хорооны болон чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл хангах, санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий/</i>	68
	8. Ажлын хэсэг байгуулах тухай Байнгын хорооны тогтоолын төсөл <i>/Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг Байнгын хорооны болон чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл хангах, санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий/</i>	68-69
	9. Ажлын хэсэг байгуулах тухай Байнгын хорооны тогтоолын төсөл <i>/Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг Байнгын хорооны болон чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл хангах, санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий/</i>	69-70

Хураангуй тэмдэглэл

Хоёр.Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2021.05.19-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга П.Сайнзориг, Мэдээллийн технологийн газрын дарга Д.Ган-Эрдэнэ нар “Жанжин Д.Сүхбаатар” танхимаас, мөн яамны Хууль зүйн бодлогын газрын шинжээч Х.Сүрэнхорол, Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрын дарга Б.Болор-Эрдэнэ, мөн газрын Мэдээллийн технологийн бодлого зохицуулалтын газрын дарга Б.Билэгдэмбэрэл, Цахим хөгжлийн үндэсний хорооны Ажлын албаны дарга С.Тэнгис, Цагдаагийн ерөнхий газрын Хуулийн хэлтсийн дарга Л.Нямдаваа, Хүний эрхийн Үндэсний комиссын гишүүн Д.Сүнжид нар цахимаар тус тус оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Бат.Баярмаа, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Хууль зүйн байнгын хороо хариуцсан референт Л.Мөнхчимэг нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаар илтгэлийг Улсын Их Хурлын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар “Жанжин Д.Сүхбаатар” танхимаас танилцуулав.

Илтгэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Л.Мөнхбаатар, Ц.Сэргэлэн, Б.Энхбаяр, Ц.Сандаг-Очир, Н.Алтанхуяг, Н.Учрал, Ж.Сүхбаатар нарын тавьсан асуултад Улсын Их Хурлын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга П.Сайнзориг, мөн яамны Мэдээллийн технологийн газрын дарга Д.Ган-Эрдэнэ нар “Жанжин Д.Сүхбаатар” танхимаас, Тагнуулын ерөнхий газрын Мэдээллийн аюулгүй байдлын газрын Мэдээллийн аюулгүй байдлыг хангах хэлтсийн дарга Д.Ганзориг цахимаар тус тус хариулж, тайлбар хийв.

Төслийн үзэл баримтлалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Сүхбаатар, Л.Мөнхбаатар нар “Жанжин Д.Сүхбаатар” танхимаас, Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнх-Оргил цахимаар тус тус үг хэлэв.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.12-т заасны дагуу санал хураалтыг MyParliament программыг ашиглан цахим хэлбэрээр явуулав.

С.Бямбацогт: Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	13
Татгалзсан:	5
Бүгд:	18

72.2 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ж.Сүхбаатар Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 12 цаг 18 минутад хэлэлцэж дуусав.

Дэлгэрэнгүй тэмдэглэл

Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэх талаарх хэлэлцүүлгийг явуулъя.

Төсөл санаачлагчийн илтгэлийг Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайд Хишгээгийн Нямбаатар танилцуулна.

Х.Нямбаатар: Хууль зүйн байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ, Монгол Улсын Их Хурлын 2020 оны 24 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан Алсын хараа 2050, Монгол Улсын Их Хурлын 2021 оны 12 дугаар тогтоолын хавсралтаар баталсан Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл зэрэг бодлогын баримт бичгүүдээр, хүний эрхийг дээдэлсэн, цахим засаглалыг дэмжсэн, технологийн аюулгүй зохистой харилцааг зохицуулсан хууль, эрх зүйн орчныг бүрдүүлэх, дэвшүүлсэн зорилтыг хэрэгжүүлэх хүрээнд Хувь хүний нууцын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл буюу Хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн төслийг боловсруулан танилцуулж байна.

Монгол Улсын Үндсэн хуулиар Монгол Улсын иргэн халдашгүй, чөлөөтэй байх, хувь хүний нууцтай байх, үүнийг хуулиар тогтоон хамгаалахаар заасны дагуу Монгол Улсын Их Хурал 1995 оны 4 дүгээр сарын 21-ний өдөр Хувь хүний нууцын тухай хуулийг баталж, мөн оныхоо 7 дугаар сарын 01-ний өдрөөс дагаж мөрдөгдөж эхэлсэн бөгөөд хувь хүний нууцыг хамгаалахтай холбогдсон харилцааг зохицуулж байгаа суурь эрх зүйн зохицуулалт юм аа.

Энэ хууль нь 3 бүлэг, 9 зүйлээс бүрдэх бөгөөд тус хуулиар хувь хүний нууцыг тодорхойлж, захидал харилцаа, эрүүл мэнд, хөрөнгө, гэр бүл, хуулиар тогтоосон бусад нууцыг хувь хүний нууцад хамруулахаар тогтоож, хувь хүний нууцыг хуулийн дагуу болон итгэмжлэлээр олж мэдсэн этгээд бусдад задруулахыг хориглох. Энэ хуулиар хамгаалсан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл шүүхэд гомдол гаргах эрхийн талаар зохицуулсан нь Монгол Улсын Үндсэн хуулиар тогтоосон хүний эрх, эрх чөлөөг баталгаажуулахад томоохон хувь нэмэр оруулсан хэдий ч нийгмийн харилцаа тасралтгүй хөгжиж байгаа, технологийн хөгжлийг дэмжсэн энэ цаг үед нийгэмд үүсээд байгаа зарим төрлийн асуудлыг хувь хүний нууцын тухай хуулиар зохицуулахад бэрхшээлтэй нөхцөл байдлууд үүссээр байгааг дурдах нь зүйтэй. Жишээ дурдвал, хувь хүний нууцын тухай хуулиар хувь хүний нууцыг хязгаарлагдмал хүрээнд тогтоож, хувь хүнийг тодорхойлох боломжтой бусад мэдээллийг хэрхэх талаар тусгаагүй, хувь хүн нууцаа өөрөө хамгаалахаар заасан нь хувь хүний мэдээллийг хариуцаж байгаа этгээд үүрэг хүлээж байгаа олон улсын жишиг зохицуулалттай нийцээгүй. Мөн хуулиар хувь хүний нууцыг задруулснаар тухайн хүнд илтэд хохирол учруулж болзошгүй гэх хэт өндөр стандартыг тогтоож, хүний эрх, эрх чөлөө зөрчигдөхөд, түүнийг хамгаалах боломжгүйд хүргэх зэргийг дурдаж болно.

Иймд Хувь хүний нууцын тухай хуулийг шинэчлэн найруулах нь зүйтэй гэж үзэн хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн төслийг боловсрууллаа.

Хуулийн төсөл нь нийт 8 бүлэг, 32 зүйлтэй. Хуулийн төсөлд зарчмын шинжтэй асуудлуудыг тусгасан. Үүнд:

1 дүгээрт, хуулийн төсөлд нэр томъёоны тодорхойлолт оруулж, хувь хүний мэдээлэл, хүний эмзэг мэдээлэл биометр, генетикийн, эрүүл мэндийн мэдээлэл зэрэг зэрэгт юуг хамруулах, эдгээр мэдээллийн эзэн хэн болох, мэдээллийг цуглуулах, боловсруулах, ашиглах ойлголтыг нарийвчлан бусад улс орны жишигт тулгуурлан нарийвчлан тодорхойллоо.

2. хувь хүний мэдээлэл цуглуулгад мэдээллийн эзнээс авдаг байх, эсхүл хуульд заасан үндэслэлээр хувь хүний мэдээлэл цуглуулах, боловсруулах, ашиглах тохиолдлыг тогтоож, хүний эрүүл мэнд, хөрөнгө, захидал харилцаа, генетик, биометр, цахим гарын үсэг, бэлгийн чиг хандлага, бэлгийн харилцааны талаарх хүний эмзэг мэдээлэл нь хувь хүний нууцад хамааруулахаар тусгасан.

3. мэдээлэл цуглуулах, боловсруулах, ашиглахад мэдээллийн эзний эдэлж болох эрх, хүлээх үүргийг тогтоож тухайн эрх нь зөрчигдсөн тохиолдолд эрхээ хамгаалуулах талаар оруулж өгсөн.

4. мэдээлэл хариуцагч буюу мэдээллийн эзний мэдээллийг цуглуулж, боловсруулж, ашиглаж байгаа этгээдийн мэдээллийн эзний өмнө хүлээх үүргийн талаар тусгасан. Мэдээлэл хариуцагч болон түүний үүргийг гэрээний үндсэн дээр шилжүүлэн авч байгаа мэдээлэл боловсруулагч, хувь хүний, хүний хувийн

мэдээлэл цуглуулах талаар аюулгүй байдлын арга хэмжээ авах, мэдээллийн эзэнд мэдээлэл цуглуулах, боловсруулах, ашиглахтай холбоотой болон илэрсэн зөрчлийг мэдэгдэх талаар оруулсан.

5. хувь хүний мэдээлэл хамгаалах эрх бүхий байгууллагыг тогтоож, Хүний эрхийн Үндэсний комисс энэ хуулийн хэрэгжилтэд хяналт тавих, харилцаа холбооны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага болон төрийн бусад байгууллага, энэ хуулийн хэрэгжилтийг зохион байгуулахтай холбоотой харилцааг зохицуулсан.

6. дуу, дүрсний бичлэгийн төхөөрөмжийг байршуулах тохиолдолд дууны, дүрсний, дуу дүрсний бичлэгийн системд тавигдах шаардлага, хориглох, хяналт тавих зохицуулалтыг тусгасан. Тухайлбал ариун цэврийн өрөө, хувцас солих өрөө, нийтийн үйлчилгээний газрын тусгай зориулалтын үйлчилгээний өрөө, караоке, зочид буудлын өрөө, эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үзүүлэх, хэвтүүлэн эмчлэх өрөө зэрэг хувь хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхэд илтэд халдахаар байршилд дүрс бичлэгийн төхөөрөмж байршуулахыг хориглохоор заасан.

Хуулийн төсөлтэй холбогдуулж хувь хүний нууцын тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай, Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай, Хүний эрхийн Үндэсний комиссын тухай хууль болон хуулийн нэршлийг өөрчилж байгаатай уялдуулан холбогдох бусад хуулиудад өөрчлөлт оруулахаар төсөлд хавсаргасан болно.

Хууль зүйн байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ, Хүний хувь хүний нууцын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл буюу хувь хүний мэдээлэл хамгаалах тухай хуулийн төсөл болон төслийн үзэл баримтлалыг хэлэлцэх эсэхийг шийдвэрлэж, дэмжиж өгөхийг та бүхнээсээ хүсье. Анхаарал хандуулсанд баярлалаа.

С.Бямбацогт: Нямбаатар сайдад баярлалаа.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан хуралдаанд оролцож байгаа ажлын хэсгийг та бүхэнд танилцуулъя.

Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд дээр ажлын хэсгийн гишүүд Дугарын Сүнжид цахимаар оролцож байна. Камераа нээцгээнэ шүү. Ажлын хэсгийн гишүүд. Пүрэвжавын Сайнзориг танхимаар оролцож байна. Ган-Эрдэнэ Хууль зүй, дотоод хэргийн яамны газрын дарга танхимаар оролцож байна. Ганзориг Тагнуулын ерөнхий газрын Мэдээллийн аюулгүй байдлын хангах хэлтсийн дарга цахимаар оролцож байгаа. Камераа нээсэн үү. Лхамдоржийн Нямдаваа Цагдаагийн ерөнхий газрын Хуулийн хэлтсийн дарга, цагдаагийн хурандаа цахимаар оролцож байна. Бадамдоржийн Билэгдэмбэрэл Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрын Мэдээллийн технологийн бодлого зохицуулалтын газрын дарга цахимаар оролцож байна. Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрын дарга Болор-Эрдэнэ бас цахимаар оролцож байгаа. Хаш-Эрдэнийн Сүрэнхорол Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын шинжээч цахимаар оролцож байна. Ийм ажлыг их суралцаж байгаа юм байна.

Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн үзэл баримтлалтай холбогдуулж төсөл санаачлагчаас асуух асуулттай гишүүд нэрсээ өгнө үү.

Сүхбаатар гишүүнээр тасаллаа. Цахимаар Сэргэлэн гишүүн, Сандаг-Очир гишүүд асуулт асууя гэсэн байна. Одоо Сэргэлэн гишүүн асуултаа асууя. Цахимаар.

Сэргэлэн гишүүн бэлэн болтол түр танхимаас асууж байя. Мөнхбаатар гишүүн асуулт асууя.

Л.Мөнхбаатар: Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн төслийг хэлэлцэх эсэхийг бол дэмжиж байгаа. Хуулийн төсөлтэй танилцсан. Хэд хэдэн тодруулах асуултууд байна.

Хувийн мэдээллийн тухайд өнөө цагт бол энэ иргэдэд үйлчилгээ үзүүлдэг бараг бүх байгууллагууд л энэ хувь хүний мэдээллийг цуглуулдаг, боловсруулдаг болчихсон. Одоо иргэд үйлчилгээ авахын тулд эмнэлэг, дэлгүүр, банк, санхүүгийн байгууллага, сургууль гэдэг юм уу одоо бүх байгууллагуудад мэдээллээ өгөөд байгаа шүү дээ.

Үүнээс гадна төрийн цуглуулсан мэдээллийг өөрийнх нь бас зөвшөөрөлтэйгөөр бас авч ашиглаж байгаа. Түүнээс гадна иргэд өөрсдөө ч мэдээгүй байхад нь одоо тухайн мэдээллийг нь ашиглаад үйлчилгээ үзүүлж байгаа. Үйлчилгээ үзүүлж байгаа юм. Ингэхээр энэ нь нэг талаасаа яах вэ, иргэнийг таних, нөгөөтээгүүр түргэн шуурхай үйлчлэхэд бол чухал байх. Гэхдээ энд бол нэг хөндөгдөж ярих ёстой нэг зүйл бол 1 дүгээрт энэ эдгээр энэ хувийн олон байгууллагууд зөвхөн өөрт шаардлагатай мэдээллээ цуглуулж байна уу, иргэдээс цуглуулж байна уу үгүй юу. Үүнээс гадна илүү олон илүү мэдээллүүдийг нэмж цуглуулаад байна уу гэдэг асуудлыг бол хөндөгдөх сэдэв мөн гэж бодоод байгаа юм.

Тухайлбал ингэдэг шүү дээ. Нэг үйлчилгээ авахад, нэг дугаар өгөхөд заавал өөрийнхөө хамааралтай нэг хүний дугаарыг өг гэдэг. Нэг хөнгөлөлтийн карт авахад регистрийн дугаар, гэрийн хаяг шаарддаг, тухайлбал зарим банкнууд байна, ийм асуулт байгаа шүү дээ. Тэр карт авахад. Танд улс төрд нөлөө бүхий, хамаарал бүхий хүн байна уу гэсэн ийм асуулт байгаа. Үүнийг бөглөж байж энэ картаа авч байх жишээтэй. Энэ мэдээллүүдийг ингэж цуглуулаад байна шүү дээ. Ийм учраас энэ хуулийн төсөлд гол яригдах зүйл бол нэг талаасаа энэ зайлшгүй хэрэгтэй мэдээллүүдээ авах ёстой байх. Түүнээс гадна аль болохоор хувь хүний мэдээллийг бага цуглуулдаг. Үүнд нь яаж хяналт тавих, энэ зохицуулалт орсон бэ гэдэг 1 дүгээр асуулт байна.

2 дугаар асуудал бол энэ гүйцэтгэх ажлын тухай хуулиар тодорхой хувь хүний мэдээллийг цуглуулах, боловсруулах асуудал нь бол зохицуулагдана аа гэсэн байна. Энэ гүйцэтгэлийн тухай хуулийн 26 дугаар зүйлээ бид нар бас эргэн харж ... /минут дуусав/

С.Бямбацогт: Нэмэлт нэг минут. Асуултаа гүйцээж асууя. Мөнхбаатар гишүүнд.

Л.Мөнхбаатар: Тэгээд энэ гүйцэтгэх ажлын тухай хуулиа үүнтэй бас хамтад нь бас авч үзэх ёстой. Түрүүн гишүүд бас яриад байгаа. Ер нь бол хэн нэгэн хуулиас гадуур гүйцэтгэх ажиллагаа явуулах, ямар нэгэн байдлаар мэдээлэл цуглуулах, энэ зүйлээс хувь хүн хэрхэн яаж хамгаалагдах вэ? Нэг талаасаа яах вэ, гэмт хэрэг зөрчлийн асуудал юм шиг боловч нөгөө талаасаа энэ хувь хүний өгөгдөл, энэ мэдээллийг хамгаалах үйл ажиллагаатай холбоотой гэж үзэж байгаа. Энэ зохицуулалтууд хэрхэн орсон бэ гэдэг асуулт байна.

3 дугаар асуулт нь, бид нар өөрсдөө ингээд эрүүл мэндийн юм уу, даатгалын юм уу, банк санхүүгийн үйлчилгээ авахдаа маш их мэдээллүүдийг өгөөд байна аа. Маш их мэдээллүүдийг. Санхүүгийн байгууллагаас авахад өөрийнхөө төдийгүй өрхийнхөө бүх мэдээллүүдийг өгчхөж байгаа шүү дээ. Тэгэхээр энэ хуулиудад нь ажил үүргээ гүйцэтгэх явцдаа олж авсан мэдээллийг задруулахгүй байх гэсэн ийм л нэг ерөнхий заалт ордог. Гэтэл үүний механизм байхгүй байгаа юм. Задруулахгүй бол яах юм. Хэдийгээр яах вэ, Зөрчлийн хуулиар хариуцлага хүлээнэ гэж байгаа боловч чиг үүнийг залруулахгүй байхад механизмыг нь энэ хуульд оруулж өгөх ёстой. Энэ чиглэлээр одоо ямар зүйл заалтууд тусгагдав аа гэдэг энэ зүйлийг асууя аа.

С.Бямбацогт: Нямбаатар сайд хариулъя.

Х.Нямбаатар: Мөнхбаатар гишүүний асуултад хариулъя аа. Ер нь одоо манайд ерөөсөө хувь хүний мэдээллийг төрийн байгууллагуудаас гадна энэ үйлчилгээний бүх байгууллагууд ямар нэгэн тийм хуулийн хориг хязгааргүйгээр цуглуулж байгаа. Ялангуяа хүний биометрикүүдийг. Энэ хурууны хээг Номин худалдааны төв ч цуглуулж авч байна. Бусад үйлчилгээний байгууллагууд цуглуулаад авч байгаа юм. Тэгэхээр цаашид бид нар энэ хууль батлагдсанаар энэ мэдээллүүдийг ерөөсөө хувийн байгууллагуудад энэ хүний биометрикүүдийг ерөөсөө цуглуулахыг хориглож байгаа юм. Яагаад гэвэл энэ цаашаа алдагдвал яах вэ, хэргийн газрын үзлэг дээр энэ биометрик хурууны хээ янз бүрийн байдлаар хуулбарлагдаж, хүн хилс хэрэгт хэлмэгдэл яах вэ гээд ийм олон асуудал байгаа. Биометрик гэдгийг бид нар бас энэ хууль боловсруулж байх үед нэлээн дэлхийн бусад улс орнууд биометрик гэдэг мэдээлэлд ямар ямар мэдээллүүд байхыг судалж үзсэн. Энд одоо хүний хөдөлгөөн, алхаа гишгээнээс авахуулаад дахин давтагдашгүй тэр бүх зүйл биометрик мэдээлэлд ордог юм байна лээ. Хамгийн сүүлд Бүгд найрамдах Хятад ард улсад хүний тэр цусны урсцыг дахин давтагдашгүй байдаг биометрик мэдээлэл гээд 6 дахь төрөл болгож бас тооцсон байна лээ.

Тэгээд энэ хууль дээр маш тодорхой зааж өгсөн. Тэр хувь хүний мэдээллийг цуглуулах, боловсруулахад ашиглахад баримтлах зарчмуудыг зааж өгсөн. Саяын тэр таны хэлж байгаа тэр улс төрд нөлөө бүхий хүн тантай хамааралтай байна уу, үгүй юу гэдэг энэ зүйлийг энэ хуулийн тэр мэдээлэл цуглуулах, боловсруулахад ашиглах зарчмаараа хязгаарлаж өгч байгаа. Дээр нь энэ мэдээллийн эзнээс нь зөвшөөрөл авах байдлаар тэр хүнтэй холбоотой янз бүрийн мэдээллийг цуглуулж, боловсруулалт хийлгүйгээр олон нийтэд түгээхтэй холбоотой энэ харилцааг бас давхар зохицуулахыг зорьж байгаа.

Сайнзориг нэмээд гүйцэтгэх ажлын тухай хууль болон бусад Эрүү, зөрчлийн хуулиудтай яаж уялдуулж ... /минут дусав/

С.Бямбацогт: Сайнзориг дарга. 2 дугаар микрофон нэмж хариулъя.

П.Сайнзориг: Мөнхбаатар гишүүний асуултад хариулъя аа. Гүйцэтгэх ажлын явцад хүний хувийн мэдээллийг цуглуулах, боловсруулах, ашиглах, хамгаалахтай холбоотой харилцааг холбогдох хуулиар нь зохицуулж байгаа. Гүйцэтгэх ажлын хуулийг бас боловсронгуй болгох ажлын хэсэг Засгийн газрын түвшинд бол ажиллаж байгаа гэдэг зүйлийг танд бас хэлье ээ.

Ер нь бол аливаа зүгээр байгууллага, хувийн хэвшил, хүний хувийн мэдээллийг цуглуулж болно. Яг авах гэж байгаа зорилго, авсан зорилгынхоо хүрээнд л ашиглах ёстой. Өөр зорилгоор ашиглаж болохгүй. Одоо таны гар утсан дээр магадгүй өөр нэг одоо юу гэдэг юм, зар сурталчилгааны компаниас ингээд мэдээллүүд ирдэг. Энэ өөрөө эргээд та хаа 1 газар гар утасны мэдээллээ өгөхөд үүнийг нь бусад этгээдүүд дамжуулсан байна аа л гэсэн үг. Тэгэхээр бид цаашдаа энэ байдлыг бас хална аа гэж үзэж байгаа.

2 дугаарт, түрүүн Нямбаатар сайд биометрик мэдээллийг ерөнхийдөө хувийн хэвшлийнхэнд ашиглуулахгүй, үүнийгээ нөхөж бид нар Цахим гарын үсгийн хуулийг оруулж ирж байгаа. Тэгэхээр бид хэд бас хувийн хэвшил, энэ технологийг дэмжиж үйлчилгээ үзүүлж байгаа байгууллагууддаа бас эрх ашигт нь хөндөхгүй байх бодлогоор бас хандаж байгаа.

2 дугаарт энэ хувийн мэдээллийг цуглуулсан байхад дахин дахин энэ хувийн мэдээллээ өгөх биш тэнд цугларчихсан байгаа мэдээллийг нөгөө байгууллага руу шилжүүлэх эрхтэй байхаар зохицуулалт өгч байгаа. Тэгэхээр 1995 оны хууль маань бол хувийн мэдээллээ, та өөрөө хамгаалаарай гэсэн бол, үүнийг та өөрөө хамгаалахаасаа гадна эргээд нөгөө мэдээллийг чинь цуглуулсан байгууллага бас хамгаалах энэ аюулгүй байдлаа хангаж ажиллах нь ээ. Тэгэхээр энэ мэдээллийг хэрэглээнд зохистой оруулах, үүнээс цаг хугацаа, эдийн засгийн үр өгөөжийг хүртэх энэ байдлыг л хангасан ийм зорилгоор энэ хуулийн төсөл бол боловсруулагдсан гэдэг төсөөллийг танд хэлье.

С.Бямбацогт: Баярлалаа. Сэргэлэн гишүүн цахимаар асуултаа асууя.

Ц.Сэргэлэн: Баярлалаа. Тэгэхээр энэ хууль орж ирж байгаа дээр би их талархалтай байгаа. Энэ бол яалт ч үгүй бид ярихаас өөр аргагүй ийм асуудлуудыг хөндсөн зохицуулалтыг оруулж ирж байгаа юм. Ялангуяа хувь хүний нууцтай холбоотой асуудал. Бид аман яриагаар ярьдаг шүү дээ. Хувийн нууцыг хуулиар хамгаална аа гэж. Тэгэхээр энэ хувь хүний нууцыг хамгаалах асуудал бол төрийн үүрэг. Төр энэ хувь хүний нууцыг хамгаалах үүрэгтэй. Энэ үүргээ хэрэгжүүлэх нэг томоохон алхмыг хийж байна гэж би харж үзэж байна. Тэгэхээр концепцын хүрээнд бол би дэмжиж байгаа. Энэ хуулийг.

Энэ дээр нэг л зарчим би хэлье гэж бодоод байгаа юм. Ерөөсөө хувь хүний нууцын тухай асуудлыг бол хувь хүн өөрөө зөвшөөрсөн тохиолдолд 1 дүгээрт, 2 дугаарт, хууль хяналтын байгууллага, тэр дундаа шүүх, прокурор зөвшөөрсөн тохиолдолд энэ хувь хүний асуудлыг хөнддөг. Бусдад өгдөг ийм л байх ёстой. Тэгэхгүйгээр, хувь хүний нууцтай холбоотой олон мэдээллийг агуулж байгаа. Төрийн ч болон хувийн хэвшлийн олон аж ахуйн нэгжүүд байж байгаа. Жишээлбэл Монгол Улсын хилээр нэвтэрсэн эсэх тухай лавлагааг авдаг. Зүгээр ажлын байдлаар ярьж байгаад одоо бол шүүх, прокурорын шатанд л энэ асуудлыг гаргаж өгдөг. Лавлагаа.

Эцэст нь энэ лавлагааг гаргаж өгсөн тухайн албан тушаалтан хууль шүүхийн өмнө тухайн мэдээллийнхээ үнэн зөвийг хариуцдаг. Ийм учиртай. Тийм учраас энэ хувь хүний нууцтай холбоотой бүхий л мэдээллийг ер нь зарчмын хувьд зөвхөн өөрөө зөвшөөрсөн тохиолдолд, 2 дугаарт, хууль хяналтын байгууллагын зөвшөөрлөөр л бусдад дамжуулдаг байхгүй бол хэн нэгний зөвшөөрөлгүйгээр дураараа хэвлэн нийтэлдэг, олон нийтийн мэдээллийн хэрэгслээр тараадаг. Тэгээд ийм байдал хавтгайрчихлаа шүү дээ. Тэгээд үүнээс болоод асар их маргаан дагуулдаг. Хувь хүний нэр төр сэвтдэг. Ийм асуудал үүсээд байна аа. Тийм учраас энэ хуулиараа яг миний хэлдэг саяын энэ зарчим ... /минут дуусав/

С.Бямбацогт: Тодруулах уу. Хэн хариулах вэ? Нямбаатар сайд. Сайнзориг. 2 дугаар микрофон.

П.Сайнзориг: Сэргэлэн гишүүний асуултад хариулъя. Сэргэлэн гишүүн бас энэ хуулийн бас гол үзэл санааг ярьж байна. Эргээд энэ хувь хүний мэдээллийг цуглуулах боловсруулахдаа тухайн хүний зөвшөөрлөөр, эсвэл үнэхээр тухайн тэр төрийн болоод хувийн хэвшлийн байгууллага хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэх хүрээнд байна уу. Жишээ нь банк бол мэдээж тодорхой мэдээллүүдийг харилцагч үүсгэхийн тулд бол хуульд заасны дагуу харилцагчаа таньж болох үүднээс цуглуулж байгаа. Ийм хүрээндээ авч байна уу гэдэг асуудал дээр энэ хяналтаа тавина.

Нөгөөтээгүүр би түрүүн хэлсэн. Энэ мэдээллийг бас авахыг тас хориглоод байж болохгүй, өгч болно, өгсөн мэдээллийг яг зорилгын дагуу ашиглаж байна уу? Хуульд заасан үндэслэлийн дагуу ашиглаж байна уу гэж байгаа. Үүнээс мэдээлэл алдагдсан тохиолдолд ямар хариуцлага хүлээлгэх вэ, хэнд гомдол гаргах вэ гэдэг процедурыг нь энэ хуулиудаар тодорхой болгож өгч байгаа. Өмнөх 1995 оны хувь хүний нууцын тухай хуулиар эдгээр асуудал байдаггүй. Эргээд яг хувь хүний нууцын мэдээлэл алдагдсан тохиолдолд шүүхээр явсан хэрэг маргаан маш цөөхөн байдаг. Ерөнхийдөө энэ эргээд шүүх, хууль сахиулах байгууллагын түвшинд ч гэсэн яг хүний хувийн мэдээлэл гэдгийг яг хэрхэн яаж тодорхойлох вэ гэдэг асуудал ч гэсэн нэлээн хүндрэлтэй, бэрхшээлтэй, маргаантай ийм асуудал байгаа. Тэгэхээр цаашдаа энэ хувийн мэдээллийг хүний зөвшөөрлөөр тухайн байгууллага дамжуулж бас үүний хэрэглээг бас авах ёстой. Жишээ нь тухайн нэг хүн эрүүл мэндийн шинжилгээ хийлгээд тухайн мэдээллийг нь нөгөө эмнэлэг рүү шилжүүлэх асуудлыг зөвшөөрлөөр нь шилжүүлчих болно. Тэгэхээр давхар давхар шинжилгээ өгөөд байхгүй, тухайн иргэндээ, бас эдийн засаг, цаг хугацааны хувьд ч гэсэн хэмнэлт үүсгэх энэ бололцоо бол бүрдэнэ ээ гэж харж байгаа. Тэгэхээр эргээд үүнийг л одоо зохистой түвшинд менежмент хийж зохицуулах, эргээд энэ дээрээсээ цаг хугацаа, зардал мөнгө хэмнэдэг эргээд хүний халдашгүй хувийн мэдээлэл, тэр орон зайг бас хамгаалсан ийм л одоо үзэл санаагаар энэ хуулийн төслийг харж байгаа.

С.Бямбацогт: Хариулт хангалттай юу. Тодруулъя. Сэргэлэн гишүүн тодруулъя.

Ц.Сэргэлэн: Ерөнхийдөө бол ойлгож байна аа. Гэхдээ би нэг л зарчим яриад байгаа юм аа. Энэ төрийн байгууллагууд хувь хүний бүхий л нууц мэдээллүүдийг агуулсан олон төрийн байгууллагууд байж байгаа шүү дээ. Улсын бүртгэлийн газар, хил хамгаалах байгууллага, Гадаадын иргэн харьяатын байгууллага гээд, би мэддэгээсээ хэлье. Гэх мэтчилэн энэ олон байгууллагууд

хэрвээ хувь хүний нууцтай холбоотой мэдээллийг бусдад дамжуулах зайлшгүй шаардлага гардаг юм бол зөвхөн хууль хяналтын байгууллагын хүсэлтээр байхаар тэр дундаа би хэлээд байна. Шүүх, прокурорын зөвшөөрлөөр үүнийг дамжуулдаг байхгүй бол эцэст нь энэ томоохон асуудалд хүрнэ ээ. Үүнийг энэ хуулиараа зохицуулж өгөх нь зүйтэй гэсэн би саналыг хэлээд байгаа юм шүү. Үүнийг бас анхаарч үзээрэй гэж ажлын хэсгийн гишүүддээ зөвлөж байна аа. Баярлалаа.

С.Бямбацогт: Нямбаатар сайд хариулъя.

Х.Нямбаатар: Баярлалаа. Би Сэргэлэн гишүүний асуултад маш товчхон хариулъя. Бид нарын энэ Хувь хүний мэдээлэл хамгаалах тухай хууль, Нийтийн мэдээллийн тухай хууль, Кибер аюулгүй байдлын хууль, Цахим гарын үсгийн хуулийн эцсийн зорилго бол яг Сэргэлэн гишүүний хэлж байгаа тэр том үр дүнд хүрэх гээд байгаа юм. Өөрөөр хэлбэл төрд агуулагдаж байгаа хувь хүний мэдээлэл рүү халдаж орж байгаа тохиолдол болгонд тухайн хүнд гар утсанд нь мессеж notracation ирдэг, ийм л зохицуулалтыг энэ 4 хуулиар хийж өгч байгаа. Өөрөөр хэлбэл хувь хүний мэдээлэлд зөвхөн хуульд заасан тэр хэмжээ хязгаарын хүрээнд халдана уу гэхээс биш эс үгүй бол улс төрийн зорилгоор юм уу, эс үгүй бол янз бүрийн субъектив зорилгоор, тэр хүний мэдээлэл рүү хэн нэг албан тушаалтан халдаж, орж байгаа тохиолдол болгонд дансыг нь үзэж байгаа тохиолдол болгонд тэр хүнд л хариу мессеж ирдэг. Түүнийгээ дагуулаад гомдол гаргаж эрхээ хамгаалуулдаг энэ механизмыг технологийн дэвшилтэй уялдуулж бий болгохоор зорьж байгаа гэдгийг хэлье.

С.Бямбацогт: Баярлалаа. Одоо Энхбаяр гишүүн асуултаа асууя.

Б.Энхбаяр: Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн хүний үндсэн эрх, эрх чөлөөний хэсгийн 13-т Монгол Улсын иргэн халдашгүй, чөлөөтэй байх эрхтэй. Хуульд заасан үндэслэл, журмаас гадуур дур мэдэн хэнийг ч нэгжих, баривчлах, хорих, мөрдөн мөшгөх, эрх чөлөөг нь хязгаарлахыг хориглоно. Иргэний хувийн ба гэр бүл, захидал харилцааны нууц, орон байрны халдашгүй байдлыг хуулиар хамгаална аа гэсэн Үндсэн хуулийн заалт байгаа юм. Энэ үндсэн эрх бол бидний одоо хэлэлцэж байгаа хүний хувийн мэдээлэл, хамааруулах тухай хуулийн төслийн гол суурь юм аа. Өөрөөр хэлбэл яг энэ Үндсэн хуулийн үзэл санааны хүрээнд хуулийн төсөл маань батлагдах учиртай гэдгийг эхлээд хэлье. Ингээд 2 асуулт байна.

Эхлээд энэ ажлын хэсэгт бас Тагнуулын байгууллагын төлөөлөл байна гэсэн. Энэ төлөөлөл болон Хууль зүйн сайдаас энэ Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдалд халдаж, утсан харилцааг нь прокурорын зөвшөөрөлгүйгээр хянасан, бичсэн тухай мэдээлэл, та бүхэнд бүртгэгдсэн зүйл байна уу? гэдэг нэг асуулт байна.

2 дугаарт нь, энэ ковид цар тахалтай холбоотойгоор Засгийн газраас энэ иргэдийн хөдөлгөөний мэдээллийг хянаж, бүртгэж байгаа аппликейшн буюу цахим программ хангамжийг нэвтрүүлсэн. Ингээд цар тахлын сэжигтэй тохиолдолтой хавьтсан байна аа гээд 1 метрийн 1 дотор уулзалдаад өнгөрөхөд утсан харилцаагаар нь дамжуулаад тухайн 1 иргэдэд мэдээлэл өгөөд байгаа. Энэ бол хэрэг дээрээ иргэдийн хаана явж байгааг ... /минут дуусав/

С.Бямбацогт: Энхбаяр гишүүн тодруулъя.

Б.Энхбаяр: Энэ аппликейшн бол иргэдийн хаана явж байгааг өөрөөс нь зөвшөөрөл авахгүйгээр хянаж байгаа ийм ер нь бол тагнуулын программ. Одоо бол яах вэ, ковид цар тахал гээд иргэд бол сайн ингээд бүртгүүлээд аппликэйшн суулгаад байх шиг байгаа юм. Энэ мэдээлэл хаана одоо хадгалагдаж бүртгэгдэж байна аа. Монгол улсын иргэд хаана хэнтэй уулзаж байна, ямар хүмүүс хоорондоо харьцаж байна, ойртож байна гэдгийг өөрийнх нь зөвшөөрөлгүйгээр шууд хянах боломжтой ийм программ байгаа.

И-баримт.мн гэж мэдээж энэ НӨАТ-ын том Монгол Улсын хамгийн өндөр хандалттай, ийм программ байгаа, хаяг байгаа. Үүгээр бол иргэд хаана юу худалдаж авч байгаа вэ, ямар үйлчилгээ худалдаж авч байгаа вэ гэдгийг бүрэн хянаж байгаа. Энэ мэдээллийн аюулгүй байдал хэр баталгаатай байгаа вэ? Миний сураг сонссоноор зарим хакердаад ... /минут дуусав/

С.Бямбацогт: Нямбаатар сайд хариулъя. Дараа нь Тагнуулын ерөнхий газар.

Х.Нямбаатар: Би тэр эхний асуултад хариулт өгөх боломжгүй. Хууль зүй, дотоод хэргийн яам мөрдөн шалгах ажиллагаа, гүйцэтгэх ажлыг гардан зохион байгуулахгүй. Зөвхөн хууль зүйн бодлогын хувьд одоо тэдгээр байгууллагуудад дэмжлэг үзүүлж ажилладаг байгууллага байгаа. Би ийм зүйл сонсоогүй байгаа.

2 дахь асуултаас хариулж эхэлье. 2020 онд Улсын Их Хурлын гишүүн асан Жадамбаагийн Энхбаяр гишүүн бид хоёр хамтраад энэ ковид 19-ийн цар тахлын тэр тархалтыг бууруулах, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, энэ Ковидын тухай хуулийг санаачилж батлуулсан. Энэ хуулиар бүх нийтийн бэлэн байдлын зэрэг, өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэн үед Улсын онцгой комисс, түүний салбар комиссуудаас ямархуу байдлаар хөл хорио тогтоох, эрхийн хязгаарлалтууд хийх энэ зохицуулалтуудыг хийж өгсөн. Сүүлийн үед дэлхийн бараг бүх улс оронд ковидын үед ийм аппликэйшнүүдийг ашиглаж иргэдийн хөдөлгөөнийг тандах, хавьтлыг тандах ийм аппликэйшнуудыг ашиглаж байгаа. Энэ нь бол нэг талдаа Энхбаяр гишүүний хэлж байгаатай адилхан нөгөө талаар урвуугаар ашиглах юм бол хүнийг мөрдөн мөшгөх энэ бүх боломжуудыг гаргаж ирж байгаа л зүйл. Гэхдээ дэлхийн бусад улс орнууд өнөөдөр бараг бүгдээрээ ковидын үед яг энэ аппликэйшнуудыг ашиглах замаар иргэддээ сэрэмжлүүлэг өгдөг. Ийм зорилгоор энэ аппликэйшнуудыг ашиглаад явж байгаа. Энэ талын зохицуулалт өнөөдөр бас манай хууль тогтоомжид төдийлөн нарийн зохицуулагдаагүй байгаа. Ялангуяа Гамшгийн тухай хуульд энэ асуудлыг бас зохицуулах замаар үүнийг эрх зүйн зохицуулалттай болгох шаардлага байна аа гэж би харж байгаа.

Нөгөө асуудлыг энэ тагнуулын байгууллагыг төлөөлж байгаа ажилтан хариулах байх аа.

С.Бямбацогт: Ганзориг хариулъя. Цахимаар. Тагнуулын ерөнхий газар.

Д.Ганзориг: Сайн байна уу, эрхэм гишүүний асуултад хариулъя аа. Тэгэхээр гүйцэтгэх ажилтай холбоотой асуудлыг бол манай байгууллагын удирдлага Тусгай хяналтын дэд хорооноос өгсөн чиглэлийн дагуу танилцуулж байгаа. Гэмт хэрэгтэй холбоотой асуудлыг бол прокурорын байгууллагын зөвшөөрлөөр мөн танилцуулдаг байгаа. Тэгэхээр энэ дээр яг үүнтэй холбоотой

асуудлыг шууд хэлэх эрх бүхий албан тушаалтан бий биш ээ гэдгийг танд танилцуулъя аа.

С.Бямбацогт: Одоо цахимаар Сандаг-Очир гишүүн асуулт асууя.

Ц.Сандаг-Очир: Баярлалаа. Хувь хүний мэдээллийн нууцын тухай хуулийн асуудал дээр энэ хамгийн их одоо төрийн байгууллагууд, хувь хүний мэдээллийг авдаг юм байна. Нөгөө талаар бас хувийн байгууллагууд авч байгаа шүү дээ. Хамгийн их 7 булчирхайг нь тооцож авч байгаа газрууд бол энэ банкнууд байна. Үүрэн одоо телефон операторууд байна. Одоо дугаар нээе гэхэд л үйлчилгээ авъя гэхэд л одоо бүх талын мэдээллээ өгч байгаа. Тэр тусмаа банкнууд бол одоо хувь хүний бүх талын мэдээллүүдийг авч байгаа. Энэ тал дээр энэ хуульд ер нь яаж тусгаж байгаа юм. Хэрвээ энэ ажил хариуцсан улсуудаас хувь хүний мэдээлэл, нууц алдвал хариуцлага хүлээсэн юм байдаг юм уу? Өнгөрсөн хугацаанд ер нь энэ хувь хүний нууцтай холбоотой асуудлаар улс төрийн хүрээнд ч, бусад салбарт ч гэсэн ер нь хариуцлага хүлээсэн хүн байна уу. Эрүүгийн хуулиар юм уу, Зөрчлийн хуулиар юм уу, Захиргааны ерөнхий хуулиар юм уу хариуцлага хүлээсэн тохиолдол байдаг юм уу.

Ингээд бүх шатны сонгууль болдог. Нэр дэвшигч нарыг цахим орчинд хэлэх, хэлэхгүй үгээр доромжилдог, хувь хүний нууцад ханддаг, нэр хүндэд халддаг, алдар хүндэд халддаг асуудлууд байдаг. Тэгээд сонгуулийнхаа хуулиар ингээд нэг олигтой ингээд юм байдаггүй, нэг торгосон болоод өнгөрдөг. Тэгээд энэ хуулиар энэ харилцаануудыг ер нь яаж зохицуулж, яаж сайжруулж байгаа вэ? Энэ ажил хариуцсан улсууд хувь хүний яриаг хүртэл чагнах, мессежийг унших хүртэл үйлчилгээнүүд байдаг гэж ярьдаг шүү дээ. Тэгэхээр энэ тал дээр энэ оператуудын аюулгүй байдал, нууц хадгалалт хамгаалалт дээр одоо ер нь яаж зохицуулалт хийсэн юм бэ гэдгийг тодруулж асууя аа.

С.Бямбацогт: Сайнзориг дарга хариулъя. 2 дугаар микрофон.

П.Сайнзориг: Сандаг-Очир гишүүний асуултад хариулъя. Хуулийн төслийн, таны эхний асуулт буюу яг ямар горимоор, ямар зарчмаар энэ мэдээллийг цуглуулах юм бэ гэдэг асуудал байна. Өнөөдөр бол бид хэд өдөр тутам магадгүй өнөөдөр ажилд ороход хүртэл яг ажил олгогчдоо хувийн мэдээллээ өгдөг. Энэ хэрхэн яаж хамгаалагдаж байгаа юм бэ гэдэг асуудлыг бид мэддэггүй. Зарим талаараа. Магадгүй өнөөдөр банк, худалдааны төвүүдээр ордог, танд урамшуулал бонус өгөх гэж байна аа, мэдээллээ өгнө үү гэдэг. Энэ нь эргээд цуглуулагдаад, ямар хамгаалалттай байгаа юм бэ гэдгийг бид мэддэггүй. Хэнд дамжуулагдаж байгааг бид бас мэдэхгүй байна. Тэгэхээр өнөөдөр энэ үйл ажиллагаануудыг зохицуулах, цаашдаа хүний эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, халдашгүй чөлөөтэй байх, магадгүй энэ хувийн мэдээлэл алдагдсанаар хүн эдийн засаг, санхүү, сэтгэл санааны хохирол хүлээх бүрэн бололцоотой. Нийгмийн статусаа алдаж болно. Ийм олон хор үр дагавартай байдаг учраас үүнийг зохицуулж өгье өө гэдэг зорилгоор энэ хууль боловсруулагдаж байгаа.

Мэдээж мэдээллийн эзний зөвшөөрлийг авч мэдээллийг цуглуулах ёстой. Мэдээллийг цуглуулахдаа ямар зорилгоор, ямар үндэслэлээр авах гэж байгаа юм. Мэдээлэл хариуцагчийн нэр. Хуулийн этгээд бол оноосон нэр нь хэн юм. Ерөнхийдөө боловсруулах мэдээллийн жагсаалт, мэдээллийг боловсруулаад тухайн байгууллага хэчнээн хугацаанд хадгалах гэж байгаа юм. Мэдээллийг ил болгох эсэхээ 2 тал бас тохирох ёстой. Мэдээллийг бусдад дамжуулах уу, үгүй юу

гэдгээ тохиролцох ёстой. Мэдээлэл өгсөн хүн хэзээ, ямар байдлаар мэдээллийн зөвшөөрлөө цуцалж болох юм бэ гэдэг зүйлийг харилцан тохиролцож байж энэ мэдээллээ бас өгдөг больё оо гэж байгаа юм. Мэдээж бид хэд энэ олон нийгмийн харилцаанд орсон мэдээллээ зайлшгүй өгнө. Үүнийгээ бас бусдад дамжуулж энэ мэдээллээ хэрэглээнд оруулах нь бас нэг талдаа бид нарт ч гэсэн шаардлага болоод байгаа.

Энэ утасны оператор, банкны асуудал дээр бол мэдээж аюулгүй байдал энэ тэрээ бас хангаж ажиллах ёстой. Дээрээс нь энэ хувийн хэвшил гэлтгүй төрийн байгууллагууд, энэ мэдээллийг цуглуулж байгаа этгээдүүд энэ аюулгүй байдал талдаа ямар ... /минут дуусав/

С.Бямбацогт: Одоо Алтанхуяг гишүүн асуулт асууя.

Н.Алтанхуяг: Энэ хуулийн төслийг дэмжинэ ээ. Орж ирээд хэдүүлээ ярья. Надад тэгэхдээ ийм хэд хэдэн эргэлзээтэй асуудлууд байна шүү. Энэ хууль дотор ингээд биччихээд байна л даа. Нямбаатар сайд аа, мэдээлэл цуглуулах, боловсруулах, ашиглах энэ үгнүүд надад таалагдахгүй байна л даа. Та нар хэдүүлээ яах вэ, ажлын хэсэг дээр ажиллаад явахаар яах вэ. Энэ юу гэсэн хууль надад сонсогдож байна вэ гэхээр хувь хүний нууцыг хамгаалах биш. Харин мэдээлэл олж цуглуулж авна, боловсруулна ашиглана гээд байх юм. Би банкна дээр очоод мэдээлэл өгөхөд тэр цуглуулаад, боловсруулаад, ашиглаад байх юм байхгүй шүү дээ. Тэгэхээр энэ нэр томъёоноос эхлээд л энэ надад эсрэг нь сонсогдоод байна шүү. Би тэнд жаахан санаа зовж байна. Би бас ажлын хэсэгт нь орж ажиллана аа. Тэгээд дэмжиж байгаа юм. Ингэмээр байгаа юм.

Энэ хоёр төрлийн мэдээлэл байна шүү дээ. Биометрик ба эмзэг мэдээлэл гээд байна. Миний бодлоор болбол бусад газрын хуулиудыг үзье. Ерөөсөө хүний энэ энэ мэдээлэлд бол хэн ч хэзээ ч халдаж болохгүй гэж заамаар байна. Тэр тухай мэдээллийг хэн ч цуглуулж болохгүй. Ялангуяа одоо энэ би сонссон. Одоо сургийн л юм хэлчихье. Тэгэхдээ анхаарна биз. Энэ хүний эрүүл мэндийн мэдээлэл гэж байгаа юм. Хэзээ ямар эмнэлэгт үзүүлсэн, ямар юм нь ямар шинжилгээгээр юу гарсан юм. Нууц шүү дээ. Тэгээд энэ дан нь бол нэг газар байгаа юм байна лээ. Хувийн компаниуд дээр байгаа юм байна лээ. Эд нар үүнийг буруугаар ашиглахгүй гэх газар байхгүй.

Биометрикийн мэдээлэл гэдэг юм уу эмзэг мэдээллийг зохицуулж байгаад л би нэг тодорхой тооны мэдээлэлд огт гар хүрэхгүй шүү гээд хэлмээр байна. Одоо бид нар их гоё юм бодож хууль гаргадаг. Амьдрал дээрээ болбол жинхэнэ дампууруулдаг. И-баримт гэдэг юм болбол маш их чухал ач холбогдолтой болсон. Төсвийн орлогоо нэмэгдүүлсэн, иргэдэд бас, ер нь бизнест ч нэмэртэй болсон. Гэтэл энэ И-баримттай холбоотой бүх мэдээллийн бааз болбол уг нь нууц. Бид нар тэгж гаргасан. Гэтэл татварын дарга нь ... /минут дуусав/

С.Бямбацогт: Алтанхуяг гишүүн нэмэлт, асуултаа гүйцээе, минут сунгая.

Н.Алтанхуяг: Татварын дарга нь энэ мэдээллийг гаргачихсан байгаа юм. Албан бичиг нь байж байгаа юм. Ингэж болохгүй шүү дээ. Энэ бол өрсөлдөгч компаниудын хувьд асар үнэ цэнтэй мэдээлэл. Монголд ямар хэмжээний юм, ямар үнэ өртгөөр орж ирж байна, хаана яаж борлож байна. Асар том мэдээллийг болбол ингээд л ил болгоод л хийчхэж байгаа юм. Тэгээд л ажлаа хийгээд л давхиж явдаг. Тэгэхээр энэ дээр хэдүүлээ хамтраад ажиллаад юм хийе ээ. Энэ

хууль бусаар одоо энэ хүний хориглосон мэдээллийг олж авсан нөхдүүдийг яах юм. Хатуу хориглоно, ял өндөр өгнө. Ер нь хууль бусаар олж авсан мэдээллийг болбол бид нар шүүх дээр л нотлох баримт биш гэж үзээд хууль бусаар мэдээлэл олж аваад, түүнийг олон нийтэд тараасан байвал тэр ял шийтгэлийг нь оноож олон нийтэд харуулмаар байна. Одоо бол би бараг дээрээсээ эхлээд энэ дээр буруу үлгэр жишээ үзүүлж байна гэж харж байгаа шүү. Одоо хэрүүл хийгээд яах вэ. Ер нь наадах цаадахаа бодоцгоогоорой. Энэ нэг жаахан тийм ардчилсан маягийн ... /минут дуусав/

С.Бямбацогт: Сайнзориг дарга хариулчихъя.

П.Сайнзориг: Алтанхуяг гишүүний саналуудыг бид нар ажлын хэсэг гарсан тохиолдолд бас харгалзаж үзье ээ.

2 дугаарт яах вэ. Түрүүн бас Сандаг-Очир гишүүний асуултад би бас гүйцэд хариулж чадсангүй. Алтанхуяг гишүүн бас хөндөж байна. Энэ хариуцлагын асуудал. Эргээд энэ зөвшөөрөлгүй авч байгаа этгээдүүдийг яах юм. Хууль бусаар авч байгаа этгээдүүд яах юм. Зөвшөөрөл өгөөгүй байж байхад бусдын мэдээллийг бусдад дамжуулсан бол яах юм гэдэг асуудал байгаа. Тэгэхээр энэ дээр мэдээж эрүү болон зөрчлийн хууль дээр нэлээн хатуухан хариуцлагууд оноож ирж байгаа. Ялангуяа биометрик генетик мэдээллүүдийг цаашид дамжуулсан, эсвэл задалсан байх юм бол эргээд энэ дээр бол эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр ингэж орж байгаа.

Өнөөдөр эрүүгийн хуулиар бол хүний хувийн нууцад халдах, хувийн нууцыг задруулах гэсэн 2 гэмт хэрэг бол байдаг. Жилд үндсэндээ 2019 оны байдлаар 5, 6 орчим бүртгэгддэг. Жилийн дундаж нь ийм байдалтай байгаа. Ер нь энэ 1995 оноос хойш энэ хувь хүний нууцад халдах гэдэг юм уу, энэ хувийн нууцыг задруулсан гэмт хэргүүдийн бүртгэл тийм их байдаггүй. Хүмүүс ер нь энэ чиглэлийн мэдлэг их хомс байдаг юм байна лээ. Яг миний мэдээлэл алдагдчихлаа, задруулчихлаа гэдэг асуудлаа өөрсдөө мэддэггүй. Үүнийгээ хууль сахиулах байгууллагад гомдол гаргаж мэддэггүй учраас бас асуудлууд үүсдэг. Тэгэхдээ эргээд энэ асуудлыг бид нар хууль сахиулах цагдаагийн байгууллага гэхээсээ илүүтэй Хүний эрхийн Үндэсний комиссод гомдлоо гаргаж бас тодорхой хэмжээний урьдчилан шийдвэрлэх ажиллагаа явуулдаг. Үүнээсээ улбаалж эдийн засаг болон бусад хохирлоо барагдуулах бололцоог нь бас бүрдүүлэх чиглэлдээ энэ хуулийн төсөлд бас зохицуулалт орж байгаа гэдэг зүйлийг танд хэлье ээ. Баярлалаа.

С.Бямбацогт: Баярлалаа. Одоо цахимаар Учрал гишүүн асуулт асууя.

Н.Учрал: 1995 оноос хойш энэ хувь хүний нууцын хууль болбол хэрэгжиж ирсэн. Тэгэхээр одоо энэ хуулийг шинэчилж найруулах цаг бол ирсэн гэдэгтэй бол санал нэгдэж хуулийн төслийг бол дэмжиж байгаа. Гэхдээ 1 зүйл байна.

Саваа бэлдээгүй үед саалиа бэлдэж болохгүй ээ. Нэг ёсондоо тагнуулын байгууллага бас энд бас ирсэн байна. Тэгэхээр мэдээллийн аюулгүй байдлын хуулийг оруулж ирэхгүйгээр хувь хүний нууцыг хамгаална гэж болбол байхгүй шүү. Өнөөдөр дэлхий дахинд мэдээлэлд анализ хийдэг ийм компаниуд бий болоод эдийн засгийн том салбарыг бий болгож байна шүү дээ. Тэгээд үүнийг нь дагаад одоо тэр мэдээллийг хууль бусаар аваад үүнд нь анализ хийгээд бусдад зарж борлуулдаг ийм гэмт хэрэг хүртэл бий болчихлоо. Тэгэхээр мэдээллийн аюулгүй

байдлаа хамгаалах чиглэл рүү нь анхаарсан хуулиа зэрэг оруулж ирэхгүй болбол энэ хууль батлагдсанаар маш олон хүн эрсдэлд орох магадлалтай. Жишээ нь энэ хуулийн 10.6 дээр байсан, 14.1 дэх заалтууд бол байсан.

10.6 дээр болохоор юу гэж байгаа юм бэ гэхээр хэрвээ одоо нөгөө мэдээлэл хариуцаж байгаа тал нь мэдээллийн аюулгүй байдлын шаардлагыг хангасан, мэдээлэл алдагдсанаас үүсэх хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй гээд хэрвээ давагдашгүй үзсэн зүйл тулгараад мэдээллийг халдах юм болбол энэ нь одоо тухайн хүнд нь хариуцлага хүлээлгэнэ гээд байгаа байхгүй юу. Тэгээд мэдээллийн аюулгүй байдлаа бүрэн хангаж чадахгүй байгаа манай улсын нөхцөл байдалд бол маш олон хүн, албан тушаалтнууд бол үүнээс болоод бас ийм буруутай тогтоогдох ийм нөхцөл байдал болбол байгаа юм. Тэгэхээр аюулгүй байдлын хуулийг зэрэг оруулж ирэх шаардлагатай.

Дээрээс нь мэдээллийг мэдээллийн эзний бичгээр өгсөн зөвшөөрлөөр эсхүл хуульд заасан үндэслэлээр хилийн чанадад дамжуулна гэдэг нэг ийм заалт байгаа. Энэ нь болохоор банк санхүүгийн байгууллагууд бол гадаадын сервер дээр одоо мэдээллүүдээ байршуулчихдаг тохиолдлууд байгаа шүү дээ. Гэтэл тэр банк санхүүгийн байгууллагад эзэмшиж байгаа хэрэглэгч нарынхаа заавал зөвшөөрлийн үндсэн дээр тэр мэдээллийг хилийн чанадад дамжуулна гэхээр жишээ нь гадаадад сервертэй байгаа тохиолдолд бол тэр хэрэглэгч нар чинь бүгдээрээ мэдээлэл ... /минут дуусав/

С.Бямбацогт: Асуулт болчихсон уу. Нямбаатар сайд хариулъя.

Х.Нямбаатар: Учрал гишүүний асуултад хариулъя аа. Кибер аюулгүй байдлын тухай хууль Засгийн газрын хуралдаанаар орсон. Одоо Улсын Их Хурлын даргаас цаг өргөн мэдүүлэх тов хүсээд цагаа тохирчих юм бол өргөн мэдүүлнэ. Тэгээд энэ хуулиуд ингээд 4 хууль зэрэгцэж хэлэлцэгдэж явна аа. Энэ 4 хуулийг бие биеэсээ салгах аргагүй нэг нь аюулгүй байдал, нэг нь цахимд орж ирэх нэвтрэлтийн гол баталгаа. Нөгөөдүүл нь хувь хүний нууцыг хамгаалах, нөгөөдөх нь нийтийн мэдээлэл гээд. Энэ 4 хууль өөр хоорондоо уялдаатай гэдгийг хэлье.

2 дугаарт тэр Учрал гишүүний хөндөж байгаа, гадаадад серверт байршуулж байгаа мэдээллийн аюулгүй байдалтай холбоотой асуудлыг энэ ерөөсөө дэлхий нийтээрээ л нэг ийм стандартыг бариад явж байгаа. Энэ бол серверийн аюулгүй байдлаа хаана хамгаалуулах вэ гэдгээ тэр мэдээлэл дата баазыг эзэмшиж байгаа нөхдүүдийн л одоо шийдвэрлэх өөрсдийнх нь асуудал байгаа. Манай улсын хувьд бол яах вэ, одоо энэ кибр аюулгүй байдлын хуулийн үзэл баримтлал дээр нэг зарчмын бас нэг эцэслэн шийдээгүй 2 асуудал байгаа юм. Энэ кибер аюулгүй байдлынхаа одоо үндсэн манаачаар нь ямар байгууллага байх вэ гэдэг бас нэг тийм хоёр талын зөрчилдөөнтэй асуудал орж ирж байгаа юм. Үүнийг бас Их Хурал дээр эцэслэж шийдэх нь зөв байх гэж ойлгож байгаа. Кибер аюулгүй байдлын хууль өөрөө энэ 4 хуулийнхаа аюулгүй байдлыг хангахаас гадна бусад дата мэдээллүүдийн аюулгүй байдал, гаднын халдлага довтолгооноос урьдчилан сэргийлэх бүх зохицуулалтыг давхар бас тусгасан. Ийм зохицуулалттай хууль болж орж ирж байгаа гэдгийг хэлье.

Сайнзориг нэмээд хариулъя.

С.Бямбацогт: 2 дугаар микрофон нэмж хариулъя.

П.Сайнзориг: Учрал гишүүний асуултад хариулъя. Тэр нийтийн мэдээллийн хууль дээр дурдагдсан зарим асуудлыг бас ярьж байна. Ерөнхийдөө үндсэн систем буюу энэ бол Монгол улсын нутаг дэвсгэр дээрээ байх юм. Дэмжих болон бусад системүүд, угаасаа энэ технологийн шийдлээсээ хаана ч байж болохоор ийм зүйл байж байгаа.

Хувь хүний мэдээллийг хилийн чанадад өгч болох уу гэдэг асуудал байгаа юм. Эсвэл өөрийнх нь зөвшөөрлөөр юм уу, олон улсын гэрээ контрактад заасны дагуу. Өнөөдөр яах вэ, Зүгээр нэг жишээ дурдахад, магадгүй хувь хүн тодорхой нэг гадаад улсад эмчилгээ хийлгэх эсвэл боловсролын байгууллагад элсэн суралцахтай холбоотой мэдээллийг энэ дээр шилжүүлчих асуудал бас байгаа. Ялангуяа эндэх эмнэлгийнхээ шинжилгээний хариуг нөгөө Солонгос ч гэдэг юм уу, аль нэг улсад эмчилгээ хийлгэж байхдаа тэр эмнэлэг рүү шилжүүлдэг. Тэгэхээр үүнийг өөрийнх нь зөвшөөрлөөр хувь хүний мэдээллийг шилжүүлж байна аа гэж үзэж байгаа.

2 дугаарт, магадгүй олон улсын байгууллага, олон улсын гэрээгээр хүлээсэн үүргийн дагуу зарим мэдээллийг шилжүүлж болно. Өөрөөр хэлэх юм бол интерпол ч байдаг юм уу. Эргээд энэ зарим статистик мэдээллүүдийг бас энэ НҮБ-ын төрөлжсөн байгууллагуудад бид хэд гаргаж өгдөг. Энэ хүрээндээ тодорхой мэдээллүүдийг бас олон улсын гэрээ конвенц заасны дагуу бас хүргүүлдэг. Энэ зохицуулалт бас орсон байгаа. Энэ агуулгаар.

С.Бямбацогт: Хариулт хангалттай юу Учрал гишүүн ээ. Хангалттай юм шиг байна. Одоо Сүхбаатар гишүүн асуултаа асууя. Гар өргөж байна уу. Тодруулъя.

Учрал гишүүн нэмэлт юмнууд тодруулъя.

Н.Учрал: Улсын бүртгэлийн хуулийг өмнө нь батлахад кодлогдсон хараат бус технологиор суурилж бүртгэнэ ээ гээд х нөгөө блокчэйн технологийг Монголоор орчуулаад ингээд тэр нэг заалт оруулсан. Тэгээд сүүлд энэ ёсчлохдоо энэ заалтыг аваад хаячихсан юм уу, яачихсан юм. Тэгэхээр ер нь энэ кодлогдсон технологид ч гэдэг юм уу, энэ засаж залруулахгүй байх үүднээс нь нэлээн анхаарах хэрэгтэй байна аа. Дээрээс нь энэ төрийн байгууллагуудад хэлэхэд цахим шилжилт хийх нэрийдлээр мэдээлэл технологийн олон төв байгуулж, хүн хүчийг улам зузаатгаж, хүнд суртлыг улам нэмэгдүүлж, хүний нөөцөө нэмэгдүүлж, цалин хөлс нэмж байснаас чинь болоод хувь хүний маш олон мэдээллүүдийг тал талд цуглуулдаг. Энэ байдал чинь бол хэрээс хэтэрлээ. Үүнээс болж маш их мэдээлэл алдагдаж байна аа. Үүнийг хуулиар зохицуулах бас шаардлагатай шүү. Тэгээд үүнийг ажлын хэсэг дээр заавал одоо ярилцах шаардлагатай байна аа.

С.Бямбацогт: Ган-Эрдэнэ 6 дугаар микрофон хариулъя.

Д.Ган-Эрдэнэ: Учрал гишүүний асуултад хариулъя аа. Төрийн байгууллага хоорондоо мэдээлэл солилцохдоо, ер нь бол энэ мэдээлэл цуглуулах, боловсруулах, ашиглахтай холбоотой асуудлыг цуглуулсан мэдээллийг бусдад дамжуулахдаа заавал эзнээс нь зөвшөөрөл авахтай холбоотой асуудлыг энэ дээр оруулсан байгаа.

18 дугаар зүйл дээр бол энэ цуглуулахтай холбоотой асуудлыг нэлээн дэлгэрэнгүй, өөр олон зүйл заалтаар оруулж өгсөн байгаа.

Мөн Архивын тухай хууль 12 сард батлагдсан. Үүгээр бол төрийн байгууллага хоорондоо үйл ажиллагаа явуулахдаа мөн хувь хүний, байгууллагын нууцтай холбоотой асуудлыг хэрхэн яаж дамжуулах вэ гэдэг асуудал.

Цахимаар албан хэрэг хөтлөлттэй холбоотой асуудал дээр хувь хүний нууцтай холбоотой мэдээллийг хүний мэдээлэл, байгууллагын нууцтай холбоотой асуудлыг хэрхэн яаж цахимаар дамжуулах вэ гэдэг тэр эрх зүйн боломжийг нь бол Архивын хуулиар бол нээж өгсөн байгаа.

Түрүүн тэр өмнөх Учрал гишүүний асуусан тэр гадаадад байгаа мэдээллийн сантай холбоотой асуудалд эргэж хэлэхэд Нийтийн мэдээллийн тухай хууль дээр бол суурь, төрөлжсөн бүртгэл мэдээллийн сан гэж 2 байдлаар хүргэж өгсөн.

С.Бямбацогт: Сүхбаатар гишүүн асуулт асууя.

Ж.Сүхбаатар: Би 1 асуулт л асууя гэж бодож байгаа юм. Энэ хуулийн хувьд бол үнэхээр цаг үеэ олсон байгаа. Сая бид нар Хүний эрхийн Үндэсний комиссын хүний эрх, эрх чөлөөний төлөв байдлын 19, 20 дугаар илтгэлийг ингээд хэлэлцээд явж байгаа. Улсын Их Хуралд танилцуулах байх гэж бодож байна. Байнгын хороо бол танилцчихсан. Тэгээд түүн дээр бол байсан юм. Хувь хүний нууцын тухай асуудал дээр болбол их ерөнхий заагдсан байна аа гээд энэ хүний эрхийн комиссоос орж л дээ. Тэгэхээр энэ илтгэлийнхээ амийг одоо хэр тусгасан бол оо? Ямар ч байсан Хүний эрхийн Үндэсний комиссын гишүүн тодорхой чиг үүрэг эд нар хариуцна гээд бас эзэнтэй. Өмнөх хуулиа бодвол бас жоохон нарийвчилсан юм бол байна. Энэ талаас нь болбол бас энэ Хүний эрхийн Үндэсний комиссын илтгэлтэй нь холбож өг гэж, бас яаж энэ асуудлуудаа авч үзэж байна гэдэг асуудлыг асууя.

2 дугаарт, нэг анхаарал татаж байгаа юм байгаа. Одоо үүнийг Байнгын хорооны хуралдааныг үзэж байгаа хүн болгон нэг л юм байгаа юм. Энэ Монголд нэг утсаар нэг чөлөөтэй ярьж болж байна уу, үгүй юу гэж жирийн иргэн хүртэл чагнаж байгаад л гэдэг. Хүний хувийн амьдрал гэдэг бол хүний оршихуйн хүний эрхийн хамгийн чухал орон зай. Тэр хүний одоо банкаар хийсэн гүйлгээг нь нэг цахим дээр хэн нэгэн нөхөр авчраад л тавьчихдаг. Хоорондоо харилцсан фэйсбүүк мессенжер дээр бичсэн юмыг нь ингээд тавьчихдаг. Скрин шотуудыг нь гаргаад тавьчихдаг. Тэгээд эрүүгийн хууль дээр болохоор мундаг том ялтай л гээд байгаа юм. Жишээлбэл хувь хүний нууцыг задруулах дээр албан тушаалтан биш хүн задруулсан бол 450 000-5400 000 төгрөгөөр торгоно. Тэгээд нэг хэдэн цаг нийтэд тустай ажил хийлгээд, эсхүл 1 сараас 1 жил хүртэл зорчих эрхийг нь хязгаарлах ял шийтгэл гэгчихсэн. Задруулбал албан тушаалтан бус хүн байвал хорих ял байхгүй. Тэгээд хүний хувийн амьдралд халдаж, хүний хувийн амьдрал бусниулж байгаа этгээд шүү дээ тэр чинь. Амь насанд нь халдсанаас дутахгүй. Тэгээд үүгээр ингээд аваад үзэх юм бол эрүүгийнх нь өмнө ч гэсэн эргэлзээтэй.

С.Бямбацогт: Сүхбаатар гишүүн тодруулъя.

Ж.Сүхбаатар: Хүмүүс бол мэдээж хандахгүй байгаад байгаа нь тэгнэ шүү дээ. Сайнзориг оо. Хэдхэн хүн л ханддаг юм байна шүү дээ. Нэг хэдхэн шиг. Үгүй ээ, тэр чинь угаасаа хариуцлага хүлээхгүй юм чинь. Олигтой ч ял байхгүй. Тэгээд тэр нь ч тодорхойгүй. Тэгээд энэ хууль зүйн салбар бол Хууль зүйн сайд үүнийг анхаарах хэрэгтэй. Хэний үед одоо нэг утсаар чөлөөтэй ярьж болдог болох болов оо. Утсаараа ярьж болохгүй шүү дээ, хүмүүс чинь. Гүйцэтгэх ажил хий, энэ одоо

гүйцэтгэх ажлын хуультай холбогдож байгаа шүү дээ. Энэ хувь хүний нууц хамгаална гээд элэнцийг нь хамгаалах вэ дээ. Бид нар чинь. Хүн утсаараа ч ярьж чадахгүй, хувиараа хоорондоо ярьж байгаа утсаа олигтой ярьж чадахгүй ийм орчинд байгаад байгаа байхгүй юу даа. Тэгээд энэ орчныг устгаж үгүй хийх хэрэгтэй байна шүү дээ. Үүнийг зөрчиж байгаа этгээдүүд ял авмаар байна шүү дээ. Өөрсдөө амьдралгүй болмоор байна шүү дээ. Тэгээд үүнийг л хийх ёстой байхгүй юу.

Тэгээд л хүний одоо захидал харилцааны нууцыг ингээд л задлаад л, сүүлдээ банкны хуулгыг нь ч гэсэн ингээд л гаргаж тавиад л. Энд бол хатуу ял цээрлэл хүлээдэггүй болбол бид ... /минут дуусав/

С.Бямбацогт: Нямбаатар сайд хариулъя.

Х.Нямбаатар: Сүхбаатар гишүүний асуултад хариулъя. Ер нь бол юу шүү дээ. Бидний яриад байгаа бүх зүйл нэг өнцөг дээр л цугларч байгаа. Энэ бол хүний өөрийн тэр хувийн орон зай гэж нэг юм зайлшгүй байх ёстой. Өнгөрсөн жилүүдэд тагнуулын дарга асан хүн Улсын Их Хурлын гишүүн, тухайн үеийн Хэрэг эрхлэх газрын дарга, одоогийн Ерөнхий сайд болон намайг бас тагнаж чагнасан асуудал яригдаад тэр хэрэг тэр хуулийн байгууллага дээр аль шатанд байгаа нь мэдэгдэхгүй дүлийрчихсэн. Яагаад гэвэл Хууль зүй, дотоод хэргийн сайд аливаа байгууллагын мөрдөн шалгах ажиллагаа, гүйцэтгэх ажилд хөндлөнгөөс оролцох ямар ч тийм зохицуулалтгүй л байгаа. Тэгэхээр цаашид энэ гүйцэтгэх ажил явуулдаг, энэ чиг үүрэгтэй байгууллагууд энэ гүйцэтгэх ажлын хууль тогтоомжийг хэмжээ хязгаарыг хэтрүүлэх эсхүл хууль бусаар энэ гүйцэтгэх ажиллагаа явуулж байгаа тохиолдолд оногдуулдаг ял шийтгэлийн бодлогоо чангатгая гээд Монгол Улсын Эрүүгийн хуульд оруулж байгаа нэмэлт өөрчлөлт, түүн дээр нэмээд эрүүдэн шүүлттэй холбоотой ялын бодлогыг чангатгах гээд ийм суурь эрүүгийн хуулийн өөрчлөлтийг оруулахаар бид бэлтгээд ажиллаж байгаа.

Дээр нь нэмээд энэ хувь хүний мэдээлэл хамгаалах тухай хууль дээр энэ зохицуулалтаа маш тодорхой болгож өгье өө. Энэ дээр Сүхбаатар гишүүнийг хамтраад ажиллаач ээ. Энэ ажлын хэсэгт ороод хэдүүлээ энэ хууль тогтоомжуудаар хүний эрхийг хангах тал дээр хамтарч ажиллахад нээлттэй байна аа.

С.Бямбацогт: Баярлалаа.

Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Хуулийн төслийн үзэл баримтлалтай холбогдуулж үг хэлэх гишүүд нэрсээ өгнө үү.

Мөнхбаатар гишүүнээр тасаллаа. Цахимаар Мөнх-Оргил, Дэлгэрсайхан, Учрал гишүүд багаа юм уу. Сүхбаатар гишүүн асуулт асууя.

Ж.Сүхбаатар: Би энэ сая Нямбаатар сайд надад санал тавьж байна. Тэгээд би энэ ажлын хэсэг, хэд хэдэн ажлын хэсэг ахалж байгаа л даа. Гэхдээ энэ бол миний хувьд болбол одоо нийтийн өмнө хүлээсэн үүрэг учраас, магадгүй бусад гишүүд хэн нь санал гаргах ажлын хэсэг байгуулахад би энэ ажлын хэсгийг ахалмаар байна. Ерөөсөө хүн өөрсдийгөө манай Хууль зүйн сайд бол өөрсдөө өөрийгөө би одоо хохирогч шүү дээ. Би өөрийгөө ч хамгаалж чадахгүй байгаа гэж ярьж байна шүү дээ. Тэгэхээр одоо хамгаалж сурах эрхтэй. Хууль зүйн сайд нь ч өөрийгөө хамгаалж чаддаггүй, Их Хурлын гишүүд нь ч одоо өөрсдийгөө хамгаалж

чаддаггүй. Тэгчхээд, иргэдийн эрх, хувийн мэдээлэл, орон зай, амьдралыг нь хамгаална гээд ингээд үлгэрийн юм ярьцгаагаад. Нөгөө үлгэрийн баатрууд шиг юм болчихоод байна шүү дээ. Тэгэхээр энэ удаагийн Улсын Их Хурал энэ хүний хувийн мэдээллийг хамгаалсан шиг хамгаалъя, тодорхой зааж өгье. Тэгээд үүнийг зөрчсөн этгээд нь ял хариуцлага аваад жинхэнээсээ асуудалд өөрөө ордог байя. Утсаар ярьж байгаа хүн, иргэн айж утсаар ярьж амьдардаг биш, тэрийг чагнах гэж байгаа, тэрийг задруулах гэж байгаа этгээд айж амьдардаг, ажилладаг байх ёстой. Айдас хүйдэс бол албан тушаалтан энэ хувийн мэдээллүүдийг ашиглах гэж байгаа этгээдэд байх ёстой байхгүй юу. Энэ хувийн мэдээллээ хамгаалж, энэ орон зай дээрээ амьдрах гэж байгаа этгээд нь өөрөө үргэлж айдас дунд байж болохгүй. Юуны дарангуйлал манай нийгэмд байна уу гээд тэгэхээр энэ улс төрийн утгаар нь яриад байгаа болохоос биш үнэндээ бол дур зоргоороо авирладаг, давуу мэдээлэл эзэмшдэг, түүнийг ашиглаад сурчихсан, гарчихсан цахим орчинд хийгээд төрийн албанд, хувийн хэвшилд ашиглаад сурчихсан, энэ мэдээлэл дээр ажилладаг сүлжээ байна шүү дээ. Гаршсан. Дата төвийн хамгаалалт ч ямар байгаа юм бүү мэд. Бүртгэл дээр ямар байгаа юм бүү мэд. Зарим бүлэглэлүүд ингээд хууль шүүхэд байхаас гадна мэдээллийн сүлжээнүүд дээр хүмүүсээ байршуулчихсан. Тэгээд хүний мэдээллийг өөр жирийн иргэдээр дамжуулж тараасан маягаар цахим орчинд хаяггүй маягаар ингэж цацдаг. Тэгээд ийм этгээдүүдийг таслан зогсоохын тулд бол би энэ дээр бол ажиллана гэж бодож байна.

Энэ ойрын 3 жилд бол энэ Улсын Их Хурал бол хүний хувийн мэдээллийг хамгаалах тал дээр урьд хожид байгаагүй хэмжээнд дэвшил гарах ёстой.

Хууль зүйн сайд, Их Хурлын гишүүн нь хувийн мэдээллээ хамгаалж чаддаггүй ийм улс оронд амьдраад яах юм. Ямар Орос, Хятадад амьдарч байгаа биш.

С.Бямбацогт: Мөнх-Оргил гишүүн саналаа хэлье.

Ц.Мөнх-Оргил: Баярлалаа. Засгийн газраас оруулж ирсэн хуулийн төслийг хэлэлцэхийг дэмжиж байгаа юм аа. Тэгээд бид нар энэ хуулийг шинэчилж янзалж гаргахгүй бол үнэхээр цадигaa алдаад байна л даа. Ер нь бол энэ хувь хүний нууцын тухай хууль Монголд огт хэрэгжээгүй хуулиудын нэг байгаа юм. Ерөөсөө огт хэрэгжээгүй. Тэр нь юутай холбоотой юм гэхээр ер нь манай нийгэмд энэ хувь хүний яг өөрийнх нь бусдад хамаагүй, зөвхөн өөрт нь хамаатай нэг ийм орчин хүрээлэн байх ёстой. Хувь хүний нууц гэж байх ёстой гэдэг энэ соёл байхгүйтэй холбоотой байгаа юм аа. Тэгээд хэдүүлээ энэ соёлыг бий болгож, хууль тогтоомжоороо хамгаалж хадгалахгүй бол энэ техник технологийн хөгжил чинь бол үүнийг шаардаад байна л даа. Бүх юм мэдээлэл дээр суурилдаг болчихоод байгаа учраас. Тэгээд энэ хамгийн үнэтэй цэнтэй юм чинь мэдээлэл болчихлоо шүү дээ, тийм ээ. Хүнийг дарамталж ч болдог, баяжуулж ч болдог. Одоо энэ гүүгл фэйсбүүк, твиттер эд нар чинь яагаад үнэд ороод байна. Үнэтэй том компаниуд болчхов, яагаад гэвэл хүний нууцыг л хадгалж байгаа байхгүй юу. Хүний тухай мэдээлэл цуглуулж байгаа учраас л тэгээд тэрийгээ нөгөө маркетинг, бараа бүтээгдэхүүнээ борлуулдаг, маркетинг хийдэг компаниуд зарж л эд нар чинь ашиг олоод байна шүү дээ. Тэгэхлээр үүнийг л цэгцлэх хэрэгтэй байна аа.

Тэгээд би над нэг ийм санал байгаа юм. Ер нь ялангуяа манай энэ Хууль зүйн байнгын хороо Улсын Их Хурлаар орж хэлэлцэгдэж байгаа хууль болон Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл болгон дээр энэ мэдээлэл хамгаалах

асуудал, хувь хүний нууцыг хамгаалах асуудал яаж тусгаж байна гэдгийг бүр нэг зүйл заалт болгож шалгаж үзэж харж баймаар байгаа юм аа. Жишээ нь, удахгүй батлагдах гэж байгаа энэ Хөдөлмөрийн тухай хуульд бид нар ажлын хэсэг дээрээ ярьж байгаад Нийгмийн бодлогын байнгын хороон дээр ярьж байгаад 2 шинэ том зүйл оруулсан. Нэг нь 5 заалттай нь, нөгөөдөх нь 2 заалттай том зүйл, 3 зүйл оруулсан. 44, 45, 46 гээд. Тэгээд 44 дүгээр зүйл нь бол ажил олгогч, ажилтны мэдээллийг авах, боловсруулах, хадгалах, ашиглахад тавигдах нийтлэг шаардлага гээд. Тэгээд энэ зөвхөн ажил үүрэгтэй нь холбоотой мэдээллийг авна шүү. Зөвхөн ажил үүрэгтэй нь холбоотой мэдээллийг авч өөр мэдээлэл нэхэж болохгүй шүү. Нэхэх юм бол тэрийг өгөхгүй байж болно. Тухайлбал улс төрийн нам, олон нийтийн байгууллага, үйлдвэрчний эвлэлийн гишүүнчлэлийн талаар мэдээлэл авах, боловсруулах асуухыг хориглоно гээд. Гарах зардлыг нь ажил олгогч хариуцна гээд. Тэгээд гагцхүү төрийн эрх бүхий байгууллага шаардсан тохиолдолд мэдээллийг өгнө, өөр ямар ч тохиолдолд мэдээллийг бусад этгээдүүдэд өгч болохгүй гээд. Тэгээд энэ чинь нөгөө сонгуулийн үеэр та нар санаж байна уу, үгүй юу, нөгөө их сургууль төгсөгчдийн холбоо, их сургууль төгссөн оюутнуудынхаа мэдээллийг улс төрийн намуудад, нэр дэвшигч нарт тараасан хэрэг гараад сошиалаар нэг хэсэгтээ л ... /минут дуусав/

С.Бямбацогт: Мөнх-Оргил гишүүнд баярлалаа. Мөнхбаатар гишүүн үгээ хэлье.

Л.Мөнхбаатар: Хүний хувийн мэдээллийг хамгаалах энэ хуулийг хэлэлцүүлгийн явцад бас 2 зүйлийг чухалчлан оруулах шаардлага байна аа гэж бодож байна. Орчин үед бол энэ мэдээлэл хариуцагч байгууллагууд хувийн мэдээллийн аюулгүй байдлыг хангах талаар тавигдаж байгаа нэг чухал шаардлага байгаа. Энэ бол энэ мэдээллийг устгах процессыг хялбар болгох ёстой гэж. Яагаад вэ гэхээр буруу зөрүү ташаа мэдээллүүд гарна. Сая гишүүд бас ярьж байна. Одоо хүний хувийн эрүүл мэндтэй холбоотой мэдээлэл ч гэдэг юм уу. Одоо хуулиар шаардагдаагүй мэдээлэл ил гарчихсан тохиолдолд түүнийг устгах процесс нь хялбар байх ёстой юм. Энэ процессыг энэ хуульдаа маш сайн зохицуулж оруулж ирэх ёстой. Энэ бол өөрөө хувийн мэдээллээ устгуулах, хүсэлт нь процесс нь ч хялбар байх ёстой. Түүнийг шийдвэрлэх журам нь бол хялбар байх ёстой гэсэн энэ зүйлийг 1 дүгээрт оруулах хэрэгтэй.

2 дугаарт, ер нь бусдын хувийн мэдээлэл, хувийн нь эмзэг мэдээлэлд халддаггүй байх, нийтэд түгээдэггүй байх, хүний нэр төр, алдар хүндийг унагаахгүй байх чиглэлээр хүний гэр бүлийн хувийн нууцыг хадгалах, хамгаалах, бусдад задлахгүй байх гэсэн энэ ухамсар төлөвшлийг бол багаас нь эхлэх нь зүйтэй. Ийм учраас энэ соён гэгээрүүлэх чиглэлийн ажлуудыг яаж хийх вэ гэдгээс хамаараад энэ хуулийн хэрэгжилт, энэ суурь ойлголт чинь бий болно оо. Ийм учраас энэ өөрөө энэ хувийн мэдээллийг хамгаалах суурь болох энэ заалтуудыг энэ хэлэлцүүлгийн явцад энэ хуулийн төсөлд тусгаж өгөх нь зүйтэй гэсэн ийм саналтай байгаагаа хэлье ээ.

С.Бямбацогт: Учрал гишүүн үгээ хэлье. Учрал гишүүнээр ингээд үг хэлэх хүмүүс дуусаж байгаа. Үүний дараа санал хураалт явагдана. Гишүүд бэлтгэлээ хангаж байгаарай. Учрал гишүүн үг хэлэхгүй юм шиг байна аа.

Хуулийн төслийн үзэл баримтлалтай холбогдуулан гишүүд үг хэлж дууслаа.

Одоо санал хураалт явуулъя. Бүртгэлийн санал хураалт. Гишүүдийг ирцдээ бүртгүүлнэ үү гэж хүсье ээ.

Бүртгэлийн санал хураалт.

Амарсайхан гишүүн, Дэлгэрсайхан гишүүн, Пүрэвдорж гишүүн, Сүхбаатар гишүүн, Учрал гишүүн, Цогтбаатар гишүүн, Энх-Амгалан гишүүн, Энхбаяр гишүүн ирцдээ анхааръя.

Одоо санал хураалт явуулъя.

Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалтад 18 гишүүн оролцсоноос 13 гишүүн буюу 72,2 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх талаарх хэлэлцүүлэг явуулж дууслаа.

Хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Сүхбаатар танилцуулъя.